

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Давст сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2022/90/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаангом хот 2022 он</p>	<p>Увс аймаг дахь Төрийн аудитын газар, Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Аудитор: Р.Аюуш Утас: 70453721, Цахим хаяг: Ayushr@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
3. Аудитын тайлан .....	17
3.1 Ерөнхий зүйл .....	17
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	17
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	18
3.4 Материаллаг байдал.....	18
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	19
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	19
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	20
3.8 Аудитын гол асуудал.....	20
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	20
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	21
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	21
4. Аудитын илрүүлэлт.....	21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	22



**УВС АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,  
Ө.Бадрахын гудамж  
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,  
E-mail: uvs@audit.gov.mn

2022.02.15 № МБА-2022/90/НА-СГА-ТМЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ДАВСТ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ТӨВИЙН ДАРГА О.БОЛОРТУЛГА  
ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Давст сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Давст сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Давст сумын Эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 377/А99 дүгээр тушаалыг зөрчин Ковид-19 цар тахалтай холбогдуулан олгосон санхүүжилтээс ажилтнуудад 28,000.0 мянган төгрөгийн тэтгэмж олгосон зөрчил нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалтад "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 268/А67 дугаар хамтарсан тушаалын 3.7 дахь хэсэгт "Энэхүү журмын 3.1-3.5-д заасан санхүүжилтэд эмч, эмнэлгийн ажилтын цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, эм, урвалж бодисын зэрэг шууд зардал болон холбогдох бусад шууд бус зардал багтана" гэсэн заалтуудтай нийцэхгүй, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

0200200548

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М. БАТСУУРЬ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>37,933,345.24</u></b>	<b><u>136,622,142.30</u></b>
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	00.00	6,319,991.80
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	6,319,991.80
3121	<b>Төгрөг</b>	00.00	6,319,991.80
31211	Төрийн сангийн харилцах	00.00	6,286,721.80
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	00.00	33,270.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	52,860.00	74,220,750.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	00.00	74,205,500.00
335	<b>Бусад авлага</b>	52,860.00	15,250.00
3351	Байгууллагаас авах авлага	41,860.00	15,250.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	11,000.00	00.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	37,880,485.24	56,081,400.50
351	<b>Түүхий эд материал</b>	13,711,385.84	24,200,874.50
35130	Эм боох материал	13,711,385.84	24,200,874.50
354	<b>Хангамжийн материал</b>	24,169,099.40	31,880,526.00
35410	Бичиг хэргийн материал	3,337,093.00	1,634,700.00
35420	Аж ахуйн материал	18,851,266.00	24,060,616.00
35460	Хүнсний материал	1,536,590.40	5,741,060.00
35470	Бусад хангамжийн материал	444,150.00	444,150.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>679,127,741.62</u></b>	<b><u>768,050,484.47</u></b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	679,127,741.62	768,050,484.47
392	<b>Биет хөрөнгө</b>	669,808,741.62	758,791,484.47
39201	Барилга, байгууламж, орон сууц	460,401,213.00	460,401,213.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-29,537,358.46	-42,773,405.02
39203	Авто-тээврийн хэрэгсэл	69,180,000.00	118,580,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-27,504,166.84	-36,477,500.21
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	239,619,402.05	331,379,076.01
39206	Хуримтлагдсан элэгдэл	-72,836,446.29	-97,110,148.64
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	62,256,289.32	63,026,289.32
39208	Хуримтлагдсан элэгдэл	-31,870,191.16	-38,334,039.99
39217	Ном	100,000.00	100,000.00
393	<b>Биет бус хөрөнгө</b>	9,319,000.00	9,259,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	9,804,000.00	9,804,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-485,000.00	-545,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>717,061,086.86</u></b>	<b><u>904,672,626.77</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>3,288,533.00</u></b>	<b><u>1,966,905.00</u></b>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	3,288,533.00	1,966,905.00
413	<b>Өглөг</b>	3,288,533.00	1,966,905.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	3,243,933.00	1,966,905.00
4136	<b>Бусад өглөг</b>	44,600.00	00.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	44,600.00	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>713,772,553.86</u></b>	<b><u>902,705,721.77</u></b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	713,772,553.86	902,705,721.77
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	497,263,451.26	497,263,451.26

Давст сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

51101	Өмч: - төрийн	497,263,451.26	497,263,451.26
512	Хуримтлагдсан үр дүн	165,796,621.57	354,729,789.48
51210	Өмнөх үеийн үр дүн	165,796,621.57	165,796,621.57
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	188,933,167.91
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	50,712,481.03	50,712,481.03
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>717,061,086.86</u></b>	<b><u>904,672,626.77</u></b>

2.2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/  
төгрөгөөр  
/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>434,481,546.00</b>	<b>880,631,329.46</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>48,974,850.00</b>	<b>150,189,353.46</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	48,974,850.00	150,189,353.46
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	48,974,850.00	150,189,353.46
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	89,400.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	48,885,450.00	150,189,353.46
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>385,506,696.00</b>	<b>730,441,976.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	343,402,300.00	403,477,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	343,402,300.00	403,477,700.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	10,880,000.00	221,629,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	11,680,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,880,000.00	30,398,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	179,550,200.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	20,095,100.00	21,923,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	20,095,100.00	21,923,900.00
1340	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	11,129,296.00	83,411,376.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	11,129,296.00	83,411,376.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>434,710,602.70</b>	<b>691,698,161.55</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>434,710,602.70</b>	<b>691,698,161.55</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	434,467,817.80	634,290,896.55
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	265,231,139.90	336,510,936.20
210101	Үндсэн цалин	240,586,658.00	290,294,290.15
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,028,191.00	4,965,997.77
210104	Урамшуулал	17,576,291.00	38,730,648.28
210105	Гэрээт ажлын хөлс	5,039,999.90	2,520,000.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	35,841,577.00	55,547,067.00
210201	Тэтгэврийн даатгал	25,665,917.00	43,020,878.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,616,977.00	3,923,789.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	395,702.00	2,201,599.91
210204	Ажилгүйдлийн даатгал	3,432,192.00	2,420,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,730,789.00	3,980,500.00

Давст сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	18,012,100.00	21,254,418.00
210301	Гэрэл, цахилгаан	2,127,484.00	3,174,783.00
210302	Түлш, халаалт	15,620,616.00	17,556,835.00
210303	Цэвэр, бохир ус	264,000.00	522,800.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	26,089,420.00	31,016,380.00
210401	Бичиг хэрэг	2,687,500.00	3,653,950.00
210402	Тээвэр, шатахуун	14,741,520.00	19,561,580.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,169,800.00	1,363,500.00
210404	Ном, хэвлэл	00.00	100,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,227,750.00	739,750.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,262,850.00	5,597,600.00
2105	<b>Нормативт зардал</b>	31,765,789.00	124,466,501.24
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	22,512,758.00	105,960,240.84
210502	Хоол, хүнс	9,133,031.00	17,692,660.40
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	120,000.00	813,600.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,758,500.00	6,954,500.00
210604	Урсгал засвар	1,758,500.00	6,954,500.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	1,100,000.00	811,000.00
210702	Дотоод албан томилолт	1,100,000.00	811,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	971,570.00	1,092,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	465,000.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	120,000.00	288,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	54,450.00	110,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	54,520.00	55,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	165,000.00	515,000.00
210807	Газрын төлбөр	90,600.00	90,600.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	53,697,721.90	56,637,894.11
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	637,500.00	3,630,963.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	53,060,221.90	53,006,931.11
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	242,784.90	57,407,265.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	00.00	57,400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	57,400,000.00
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	242,784.90	7,265.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	242,784.90	7,265.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-229,056.70</b>	<b>188,933,167.91</b>
225	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	1,120,000.00	00.00
225002	Найдваргүй авлагын алдагдал	1,120,000.00	00.00

4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-1,120,000.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-1,349,056.70</u>	<u>188,933,167.91</u>

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>385,596,096.00</b>	<b>656,236,476.00</b>
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>385,506,696.00</b>	<b>656,236,476.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	343,402,300.00	403,477,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	343,402,300.00	403,477,700.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	10,880,000.00	221,629,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	11,680,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,880,000.00	30,398,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	179,550,200.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	00.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	20,095,100.00	21,923,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	20,095,100.00	21,923,900.00
1340	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	11,129,296.00	9,205,876.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	11,129,296.00	9,205,876.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>385,596,096.00</b>	<b>641,926,684.20</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>385,596,096.00</b>	<b>641,926,684.20</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>385,353,311.10</b>	<b>584,519,419.20</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	265,837,002.90	339,213,293.20
210101	Үндсэн цалин	237,676,713.11	290,294,290.15
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,543,999.15	4,965,997.77
210104	Урамшуулал	17,576,290.64	39,074,649.80
210105	Гэрээт ажлын хөлс	5,040,000.00	4,878,355.48
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	33,261,500.00	54,095,128.00
210201	Тэтгэврийн даатгал	22,620,600.00	42,092,028.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,661,300.00	3,000,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,123,300.00	2,401,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	533,800.00	599,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,322,500.00	6,001,600.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	18,012,100.00	20,996,918.00
210301	Гэрэл, цахилгаан	2,127,484.00	3,174,783.00
210302	Түлш, халаалт	15,620,616.00	17,556,835.00
210303	Цэвэр, бохир ус	264,000.00	265,300.00

Давст сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	20,738,320.00	32,554,380.00
210401	Бичиг хэрэг	1,930,000.00	1,997,600.00
210402	Тээвэр, шатахуун	14,741,520.00	19,561,580.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,169,800.00	1,380,000.00
210404	Ном, хэвлэл	100,000.00	100,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,197,500.00	2,105,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,599,500.00	7,410,200.00
2105	<b>Нормативт зардал</b>	37,274,618.00	125,134,580.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	26,305,958.00	99,231,500.00
210502	Хоол, хүнс	8,868,660.00	21,423,080.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,100,000.00	4,480,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	5,724,500.00	6,850,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,495,000.00	700,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	500,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	3,729,500.00	5,650,500.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	1,100,000.00	800,000.00
210702	Дотоод албан томилолт	1,100,000.00	800,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,606,570.00	1,442,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	800,000.00	300,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	120,000.00	288,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	54,450.00	110,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	54,520.00	55,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	465,000.00	565,000.00
210807	Газрын төлбөр	90,600.00	90,600.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,798,700.20	3,432,420.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,798,700.20	3,432,420.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>242,784.90</b>	<b>57,407,265.00</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	00.00	57,400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	57,400,000.00
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	242,784.90	7,265.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	242,784.90	7,265.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>00.00</b>	<b>14,309,791.80</b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>00.00</b>	<b>7,989,800.00</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>7,989,800.00</b>

УВА-2022/90/НА-СТА-ТШЗ

2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	7,989,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	7,989,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>00.00</u>	<u>-7,989,800.00</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
14	Бусад эх үүсвэр	00.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	6,319,991.80
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	6,319,991.80

2.4 АУДИТ ХИЙСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	497,263,451.26	50,712,481.03	165,796,621.57	00.00	713,772,553.86
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	497,263,451.26	50,712,481.03	165,796,621.57	00.00	713,772,553.86
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00	00.00
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	497,263,451.26	50,712,481.03	165,796,621.57	00.00	713,772,553.86
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	497,263,451.26	50,712,481.03	165,796,621.57	00.00	713,772,553.86
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	497,263,451.26	50,712,481.03	165,796,621.57	00.00	713,772,553.86
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	188,933,167.91	00.00	188,933,167.91
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	497,263,451.26	50,712,481.03	354,729,789.48	00.00	902,705,721.77

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Тайлант оны			
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	436,750,800.00	428,313,489.20	8,437,310.80	98.1%
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	436,750,800.00	428,313,489.20	8,437,310.80	98.1%
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	436,750,800.00	428,313,489.20	8,437,310.80	98.1%
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	300,500,800.00	293,805,320.20	6,695,479.80	97.8%
Үндсэн цалин	263,389,400.00	257,858,461.15	5,530,938.85	97.9%
Унаа хоолны хөнгөлөлт	5,544,000.00	4,965,997.77	578,002.23	89.6%
Урамшуулал	26,527,400.00	26,102,505.80	424,894.20	98.4%
Гэрээт ажлын хөлс	5,040,000.00	4,878,355.48	161,644.52	96.8%
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	40,567,600.00	39,357,304.00	1,210,296.00	97.0%
Тэтгэврийн даатгал	28,547,600.00	27,354,204.00	1,193,396.00	95.8%
Тэтгэмжийн даатгал	3,005,000.00	3,000,800.00	4,200.00	99.9%
ҮОМШӨ-ний даатгал	2,404,000.00	2,401,100.00	2,900.00	99.9%
Ажилгүйдлийн даатгал	601,000.00	599,600.00	1,400.00	99.8%
Эрүүл мэндийн даатгал	6,010,000.00	6,001,600.00	8,400.00	99.9%
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	20,323,900.00	20,322,135.00	1,765.00	100.0%
Гэрэл, цахилгаан	2,500,000.00	2,500,000.00	-	100.0%
Түлш, халаалт	17,556,900.00	17,556,835.00	65.00	100.0%
Цэвэр, бохир ус	267,000.00	265,300.00	1,700.00	99.4%
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	24,801,000.00	24,792,500.00	8,500.00	100.0%
Бичиг хэрэг	1,900,000.00	1,997,600.00	(97,600.00)	105.1%
Тээвэр, шатахуун	18,021,000.00	18,021,000.00	-	100.0%
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,380,000.00	1,380,000.00	-	100.0%
Ном, хэвлэл	100,000.00	100,000.00	-	100.0%
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	1,105,000.00	95,000.00	92.1%
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,200,000.00	2,188,900.00	11,100.00	99.5%
<b>Нормативт зардал</b>	40,738,300.00	40,667,110.00	71,190.00	99.8%
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	28,369,200.00	28,369,200.00	-	100.0%
Хоол, хүнс	9,869,100.00	9,797,910.00	71,190.00	99.3%
Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,500,000.00	2,500,000.00	-	100.0%
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,700,000.00	3,694,500.00	5,500.00	99.9%
Багаж, техник, хэрэгсэл	1,600,000.00	1,600,000.00	-	100.0%

Давст сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	500,000.00	500,000.00	-	100.0%
Урсгал засвар	1,600,000.00	1,594,500.00	5,500.00	99.7%
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,150,000.00</b>	<b>800,000.00</b>	<b>350,000.00</b>	<b>69.6%</b>
Дотоод албан томилолт	1,150,000.00	800,000.00	350,000.00	69.6%
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,536,200.00</b>	<b>1,442,200.00</b>	<b>94,000.00</b>	<b>93.9%</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300,000.00	300,000.00	-	100.0%
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360,000.00	288,000.00	72,000.00	80.0%
Даатгалын үйлчилгээ	110,500.00	110,500.00	-	100.0%
Тээврийн хэрэгслийн татвар	55,100.00	55,100.00	-	100.0%
Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	33,000.00	22,000.00	60.0%
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	565,000.00	565,000.00	-	100.0%
Газрын төлбөр	90,600.00	90,600.00	-	100.0%
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>3433000.00</b>	<b>3432420.00</b>	<b>580.00</b>	<b>100.0%</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	3,433,000.00	3,432,420.00	580.00	100.0%
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>436,750,800.00</b>	<b>434,600,211.00</b>	<b>2,150,589.00</b>	<b>99.5%</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>403,477,700.00</b>	<b>403,477,700.00</b>	<b>-</b>	<b>100.0%</b>
Улсын төсвөөс санхүүжих	403,477,700.00	403,477,700.00	-	100.0%
<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>21,923,900.00</b>	<b>21,916,635.00</b>	<b>7,265.00</b>	<b>100.0%</b>
Орон нутгийн төсвөөс	21,923,900.00	21,916,635.00	7,265.00	100.0%
<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>11,349,200.00</b>	<b>9,205,876.00</b>	<b>2,143,324.00</b>	<b>81.1%</b>
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	11,349,200.00	9,205,876.00	2,143,324.00	81.1%
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>6,286,721.80</b>	<b>(6,286,721.80)</b>	
<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>22.00</b>	<b>22.00</b>	<b>-</b>	<b>100.0%</b>
Удирдах ажилтан	01.00	01.00	-	100.0%
Гүйцэтгэх ажилтан	16.00	16.00	-	100.0%
Үйлчлэх ажилтан	04.00	04.00	-	100.0%
Гэрээт ажилтан	01.00	01.00	-	100.0%

**Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>			
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>221,595,730.00</b>	(221,595,730.00)
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>221,595,730.00</b>	(221,595,730.00)
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		164,195,730.00	(164,195,730.00)
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		45,407,973.00	(45,407,973.00)
Үндсэн цалин		32,435,829.00	(32,435,829.00)
Урамшуулал		12,972,144.00	(12,972,144.00)
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		14,737,824.00	(14,737,824.00)
Тэтгэврийн даатгал		14,737,824.00	(14,737,824.00)
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>		674,783.00	(674,783.00)
Гэрэл, цахилгаан		674,783.00	(674,783.00)
<b>Хангамж, бараа материалын зардал</b>		7,761,880.00	(7,761,880.00)
Тээвэр, шатахуун		1,540,580.00	(1,540,580.00)
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		1,000,000.00	(1,000,000.00)
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		5,221,300.00	(5,221,300.00)
<b>Нормативт зардал</b>		84,467,470.00	(84,467,470.00)
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		70,862,300.00	(70,862,300.00)
Хоол, хүнс		11,625,170.00	(11,625,170.00)
Нормын хувцас, зөөлөн эдлэл		1,980,000.00	(1,980,000.00)
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		11,145,800.00	(11,145,800.00)
Багаж, техник, хэрэгсэл		7,089,800.00	(7,089,800.00)
Урсгал засвар		4,056,000.00	(4,056,000.00)
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	0.00	57400000.00	(57,400,000.00)
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		57,400,000.00	(57,400,000.00)
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		57,400,000.00	(57,400,000.00)
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	0.00	221629000.00	(221,629,000.00)
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		221,629,000.00	(221,629,000.00)
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		11,680,000.00	(11,680,000.00)
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		30,398,800.00	(30,398,800.00)

Давст сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	179,550,200.00	(179,550,200.00)
Төсвийн урамшуулал	00.00	-
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	33,270.00	

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Давст сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Р.Аюуш гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Давст сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Давст сумын Эрүүл мэндийн төв нь Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулж үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг явуулдаг байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагатай гэж үзэж шалгахад дотоод аудитын чиг үүрэг бүхий байгууллагуудаас тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Давст сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд Давст сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан гараагүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 436,984.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4,369.8 мянган төгрөгөөр тооцсон, гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 691,698.2 мянган төгрөгийн 1 хувиар буюу 6,916.9 мянган төгрөгийн 80 хувиар тооцож 5,533.6 мянган төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан гараагүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоосон.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Давст сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 187,611.5 мянган төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	6,319.9	6,319.9
Авлага	52.9	74,220.7	74,167.8
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	37,880.5	56,081.4	18,200.9
Үндсэн хөрөнгө	679,127.7	768,050.5	88,922.8
<b>Нийт хөрөнгө</b>	<b>717,061.1</b>	<b>904,672.6</b>	<b>187,611.5</b>
Өр төлбөр	3,288.5	1,966.9	-1,321.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	713,772.5	902,705.7	188,933.2
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>717,061.1</b>	<b>904,672.6</b>	<b>187,611.5</b>

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 6,319.9 мянган төгрөгөөр байгаа нь үлдэгдэл төвлөрүүлээгүйгээс шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл 74,220.7 мянган төгрөг болж 74,167.8 мянган төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилт дутуу ирснээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 56,081.4 мянган төгрөг болж 18,200.9 мянган төгрөгөөр өссөн нь Ковид-19 цар тахлаас шалтгаалан аж ахуйн материал, эм боох материал нэмэгдсэнээс шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Оны эцэст бараа материалын нөөц үүсгэсэн нь ирэх онд Ковид-19 цар тахалд зарцуулахаар байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 768,050.5 мянган төгрөг болж 88,922.8 мянган төгрөгөөр өссөн нь хандиваар 133,939.8 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, төсвийн хөрөнгөөр 7,989.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.

Өр төлбөрийн данс 1,966.9 мянган төгрөг болж 1,321.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 902,705.7 мянган төгрөг болж 188,933.2 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 446,149.8 мянган төгрөгөөр буюу 102.6 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 264,320.4 мянган төгрөгөөр буюу 40.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан цалин хөлс, байршилтай холбоотой зардал, эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардлууд байна. Энэ нь түлш халаалтын тариф өссөн, Ковид-19 цар тахалтай холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 436,350.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 435,350.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 1,032.2 мянган төгрөгөөр бууруулж 435,317.8 мянган төгрөгөөр баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 435,317.8 мянган төгрөгийн төсөв баталж, тодотголоор 436,750.8 мянган төгрөг баталснаас улсын төсвөөс 403,477.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 21,923.9 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас 11,349.2 мянган төгрөг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 403,477.7 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас 9,208.9 мянга, орон нутгийн төсвөөс 21,916.6 мянга, нийт 434,600.2 мянган төгрөгийг санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 428,320.8 мянган төгрөгийг зарцуулж, 7.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 428,320.8 мянган төгрөг буюу 98,4 хувьтай байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 221,629.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс урамшууллын зардалд 45,407.9 мянга, НДШ зардалд 14,737.8 мянга, байр ашиглалттай холбоотой зардалд 674.8 мянга, бараа материалын зардал 7,761.8 мянга, нормативт зардал 84,467.5 мянга, эд хогшил худалдан авах зардал 11,145.8 мянга, нэг удаагийн тэтгэмжийн зардалд 57,400.0 мянга, нийт 221,595.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал байхгүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108 дугаар чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Давст сумын Эрүүл мэндийн төвийн хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 141, хугацаа хоцроосон 8, мэдээлэх хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Давст сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайланд Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих төлбөрт үйлчилгээний орлогын 74,205.5 мянган төгрөгийн авлага тусгагдсан байна. 2022 оны 1 дүгээр сард санхүүжилтийг олгосон байна. Дараагийн аудитаар тухайн авлагын зарцуулалтыг нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 28,000.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 28,000.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Мөнгөн урамшуулалтай холбоотой асуудал

##### 1.1. Илрүүлэлт:

Давст сумын Эрүүл мэндийн төв нь Давст сумын Эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 377/A99 дүгээр тушаалыг зөрчин Ковид-19 цар тахалтай холбогдуулан олгосон санхүүжилтээс ажилтнуудад 28,000.0 мянган төгрөгийн тэтгэмж олгосон зөрчил нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалтад "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 268/A67 дугаар хамтарсан тушаалын 3.7 дахь хэсэгт "Энэхүү журмын 3.1-3.5-д заасан санхүүжилтэд эмч, эмнэлгийн ажилтын цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, эм, урвалж бодисын зэрэг шууд зардал болон холбогдох бусад шууд бус зардал багтана" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй алдаа зөрчилд зөвлөмж өглөө.

##### 1.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 377/A99 дүгээр тушаалыг хэрэгжүүлж ажиллах.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Давст сумын Эрүүл мэндийн төв	1	28,000.0							1	28,000.0
<b>ДҮН</b>											

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

/М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР

/М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

/Р.АЮУШ/

2022 оны 02 сарын 25-ны өдөр